



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДОА-2022/20/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот  
2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: [semjidmaai@audit.gov.mn](mailto:semjidmaai@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: [narmandakhd@audit.gov.mn](mailto:narmandakhd@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



Г БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН 1  
ГАЗРЫН ДАРГА Б.МӨНГӨНЧИМЭГ ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улаанбаатар, Хэрлэнгийн Зурвас  
ЗДТГ-ын Дугаар Утас/Факс: 3355-4202

2022.02.16 № 68

танай -ийн № -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020829

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	148.2	162.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	848.2	937.3
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>996.4</b>	<b>1,100.1</b>
	Нийт өр төлбөрийн дүн	10.2	4.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	986.2	1,095.7
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>996.4</b>	<b>1,100.1</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	534.4	577.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	471.8	465.3
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>62.6</b>	<b>111.7</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.1	2.2
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>62.5</b>	<b>109.5</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	923.7	986.2
	Тайлант оны үр дүн	62.5	109.5
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>986.2</b>	<b>1,095.7</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	431.4	427.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	394.3	404.6
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>37.1</b>	<b>22.7</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(37.1)</b>	<b>(22.7)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(0.0)</b>	<b>(0.0)</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>431.5</b>	<b>398.8</b>
	Урсгал зардал	394.3	376.1
	Хөрөнгийн зардал	37.2	22.7
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>431.5</b>	<b>425.7</b>
	Улсын төсвөөс санхүүжих	430.9	425.1
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.6	0.6

## Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх.

## Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Бараа материалын дансанд бүртгэлтэй малын тооллого хийсэн бүртгэл, тайлан байхгүй, зөвхөн А дансыг үндэслэн бүртгэл тайланд тусгасан байна.

## Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

## Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Булган сумын ЗДТГ нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 14.0 сая төгрөгийн 2 мэдээллийг ил тод байршуулаагүй, 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх оны зөрчлийг давтан гаргасан. Иймд хариуцлага тооцуулах албан шаардлага өгч ажиллалаа.

## Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

## Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар өөрийн орлого 0.2 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн, ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж зарцуулсан 1.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, үндсэн хөрөнгийн батлан хамгаалахын тоног төхөөрөмжийн дансанд ашигладаггүй 1.3 сая уурын зуух, бараа материалын дансанд бүртгэлтэй 123.7 сая төгрөгийн малын тооллого хийсэн бүртгэл, тайлан байхгүй, зөвхөн А дансыг үндэслэн бүртгэл тайланд тусгасан зөрчилд зөвлөмж өгсөн.

## 7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	126.9	4	-	-	-	-	2	1.8	2	124.9
	<b>НИЙТ</b>	<b>126.9</b>	<b>4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>2.0</b>	<b>2</b>	<b>124.9</b>